

НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ
№ НАУ-ГТТА 2022-02

2022-02-15

№ **001-5622**

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас **2699877** регистрийн дугаартай “Диспетчерийн үндэсний төв” ХХК, /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж, Зах зээл, санхүү хариуцсан дэд захирал Ц.Өнөрмаа,

нөгөө талаас **5849187** регистрийн дугаартай “МАК Аранжин Зэс” ХХК/цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Ашиглалтын Өмнөх Захиргааны дарга ажилтай Б.Мөнгөнжолоо /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон Талууд дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Гүйцэтгэгч нь “МАК Аранжин Зэс” ХХК-ийн захиалгаар: Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах 220/22 кВ-ын “Цагаансуварга” дэд станцын 22 кВ-ын хуваарилах байгууламжаас 22 кВын 2 хэлхээт 3-5 км урттай Цахилгаан дамжуулах агаарын (Техникийн нөхцөл, зургийн даалгавар боловсруулах үе шатанд кабель шугамаар цахилгаан дамжуулах эсэхийг шийдвэрлэх) шугам, 22/6 кВ-ын 2*5 мВА чадалтай дэд станц барих горимын тооцоо хийж гүйцэтгэх /цаашид “Гэрээт ажил” гэх/, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэ гэрээнд тусгагдаагүй бусад харилцааг Монгол улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Энэхүү гэрээний **Хавсралт №1-д горимын тооцооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үнэ тариф”-ыг хавсаргав.** Хавсралт №1 нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4. Энэ гэрээгээр гүйцэтгэсэн гэрээт ажил нь Талуудын оюуны өмч болох тул гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулах тохиолдолд нөгөө Талын зөвшөөрлийг заавал авна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ХУГАЦАА

- 2.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах 220/22 кВ-ын “Цагаансуварга” дэд станцын 22 кВ-ын хуваарилах байгууламжаас 22 кВын 2 хэлхээт 3-5 км урттай Цахилгаан дамжуулах агаарын (Техникийн нөхцөл, зургийн даалгавар боловсруулах үе шатанд кабель шугамаар цахилгаан дамжуулах эсэхийг шийдвэрлэх) шугам, 22/6 кВ-ын 2*5 мВА чадалтай дэд станц барихад шаардлагатай горимын тооцооны Хавсралт №1-т заасан ажлыг мэргэжлийн өндөр түвшинд, чанартай хийж гүйцэтгэн үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 2.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажлын төлбөрийг төлсөн өдрөөс эхлэн хуанлийн 45 /дөчин тав/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.3. Захиалагчаас хамаарсан болон Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.
- 2.4. Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас ажлыг зогсоох, анх өгсөн техникийн өгөгдөл, анхдагч хэлхээний зураг схемд өөрчлөлт орж ажлыг дахин хийх шаардлага гарвал талууд тухайн асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Гэрээт ажлын нийт төлбөр нь татвар хураамж /НӨАТ/ багтсан дүнгээр **9,900,000.00 (есөн сая есөн зуун мянга)** төгрөг байна.
- 3.2 Энэ гэрээний нийт төлбөрт Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг хийж гүйцэтгэх ажлын хөлс, шаардлагатай материал, ажилтны цалин хөлс, бүх татвар, хураамж болон зардал багтсан болно.
- 3.3 Гэрээний төлбөрийг Захиалагч нь Гүйцэтгэгчид дор дурдсан хуваарийн дагуу Гүйцэтгэгчийн дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ. Үүнд:
 - 3.3.1. Захиалагч нь энэхүү нэмэлт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дотор гэрээний нийт үнийн дүнгийн 60%-ийн төлбөр болох 5,940,000.00 (таван сая есөн зуун дөчин мянга) төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн, түүний харилцах дансанд шилжүүлнэ.
 - 3.3.2. Тооцоо дуусаж гэрээ дүгнэсэн акт баталгаажуулахад бэлэн болсон үед үлдэгдэл төлбөр 3,960,000.00 төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд ажлын 3 /гурав/ хоногийн дотор шилжүүлнэ.
- 3.4 Захиалагч нь зөвхөн Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн ажлын үр дүнд тохирох төлбөрийг тооцож төлнө.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ТЭЗҮ, Нэгдсэн сүлжээтэй холбогдох схем, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын үндсэн тоноглолын өгөгдөл зэрэг бусад шаардлагатай мэдээллээр бүрэн хангана.
- 4.2 Хийгдэх ажлын хэмжээ өөрчлөгдөх, зогсоох шаардлага гарвал Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэх, гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гарвал Гүйцэтгэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 4.3 Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас ажлыг зогсоох, анх өгсөн техникийн өгөгдөл, анхдагч хэлхээний зураг схемд өөрчлөлт орж ажлыг дахин хийх шаардлага гарвал холбогдох зардал, ажлын хөлсийг Гүйцэтгэгчид нэмж төлнө.
- 4.4 Захиалагч нь зураг төслийн болон бусад холбогдох норм дүрэм, стандартыг Гүйцэтгэгч зөрчсөн болон чанарын гологдол гаргасан нь тогтоогдсон тохиолдолд уг доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.5 Захиалагч нь Гүйцэтгэгчээс гэрээт ажлын гүйцэтгэлийг албан тоот болон гэрээ дүгнэсэн актаар хүлээн авна.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Гүйцэтгэгч нь Захиалагчаас шаардагдах өгөгдөл, схем, мэдээллийг болон Захиалагчийн төлбөр төлсөн баримт зэргийг бүрэн хүлээн авснаар гэрээт ажлыг эхэлнэ.
- 5.2 Гэрээт ажлыг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж гэрээнд заасан хугацаанд багтаан Захиалагчид гэрээт ажлын гүйцэтгэлийг актаар хүлээлгэн өгнө.
- 5.3 Гэрээт ажлын явцад алдаа гарсан нь илэрч зураг төслийн ажлын явцад хүндрэл үүсгэвэл Гүйцэтгэгч өөрийн хүч хөрөнгөөр илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах үүрэг хүлээнэ.
- 5.4 Гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүн нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэгдсэн, техникийн нөхцөл, зургийн даалгаврыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Захиалагчийн дахин тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөөр мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж гэрээт ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн актаар хүлээлгэн өгнө.
- 5.5 Захиалагчаас шилжүүлэн өгсөн аливаа баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

- 5.6 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд Захиалагчаас авсан техникийн үзүүлэлт, тооцоо, баримт материал зэргийг гэрээт ажил дууссаны дараа Захиалагчид хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Захиалагч төлбөрийг гэрээнд заасан журмаар төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алданги төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 6.3 Талуудын гэрээгээр хүлээсэн үүргээс үүсэх алданги төлөх дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн 10 %-аас хэтрэхгүй байна.
- 6.4 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг алдаатай алдаатай гүйцэтгэсний улмаас Захиалагчид хохирол учирсан тохиолдолд Гүйцэтгэгч нь үл маргах журмаар нөхөн төлнө.
- 6.5 Захиалагчийн буруугаас гэрээт ажлын гүйцэтгэл үр дүнгүй болж дахин горимын тооцоо хийх болсон тохиолдолд Захиалагч үл маргах журмаар Гүйцэтгэгчид дахин төлбөр төлнө.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ

- 7.1. Гүйцэтгэгч нь Захиалагчид гэрээт ажлыг албан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээнд заагдсан хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.
- 7.2. Талууд гэрээт ажлыг гэрээний гүйцэтгэлийг хүлээлцэх актаар баталгаажуулна.


НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал гаргасан Тал нь албан бичгээр нөгөө талдаа саналаа хүргүүлнэ. Хүлээн авсан Тал нь ажлын 5 хоногт хариуг албан бичгээр хүргэнэ.
- 8.2 Нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан зөвшөөрсөн тохиолдолд тус өөрчлөлтийг бичгээр үйлдэх бөгөөд Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.3 Энэ гэрээний нөхцөлүүдийг зөрчсөн буюу гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 8.4 Гэрээнээс үүссэн маргааны зөвшилцлийг эс зөвшөөрсөн Тал нь Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5 Энэ гэрээг 3 /гурав/ эх хувь үйлдэж, баталгаажуулах ба Захиалагч 2 хувь, Гүйцэтгэгч 1 эх хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 8.6 Гэрээт ажлыг Талууд бүрэн хүлээлцэж, төлбөр тооцоог 100 хувь барагдуулсанаар гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн
Гүйцэтгэх захирал


..... Г.Балжинням
Зах зээл, санхүү хариуцсан дэд
захирал
..... Ц.Өнөрмаа - 2

Захиалагчийг төлөөлж:

“МАК Аранжин Зэс” ХХК-ийн:


УЛААНБААТАР ХОТ
Ашиглалтын өмнөх Захиргааны дарга
..... Б.Мөнгөнжолоо

Тэргүүн дэд захирал бөгөөд
Ерөнхий диспетчер


..... Б. Баатар

СЭЗА-ны дарга


..... Т.Бямбажав


ГТТА-ны дарга


..... Х.Болд-Эрдэнэ


ЗЗЗА-ны дарга


..... Г.Мөнхбат

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн


..... Ч.Отгонбаатар

Гэрээний мэргэжилтэн


..... Д.Алимаа

Эрх зүйн газрын Ахлах Хуульч


..... Т.Жавхлан

Захиалагчийн хаяг:

17030 Улаанбаатар хот
Хан-Уул дүүрэг, 1-р хороо
19 хороолол Чингисийн
Өргөн чөлөө МАК ХХК-ийн
Төв байр.Шуудангийн хайрцаг-66
Утас-75759700, факс-70107481
И-мэйл:mak@mak.mn

Гүйцэтгэгчийн хаяг:

17032. Улаанбаатар хот
Хан-уул дүүрэг, Чингисийн
Өргөн чөлөө. Засгийн газрын XIV байр
Утас: 70041371
Факс: 70043467
И-мэйл:ndc@ndc.energy.mn









Нэмэлт ажил үйлчилгээний 2022 оны 02 сарын 15-ны өдрийн
 "НАУ-177А 2022-02" тоот гэрээний хавсралт-1

Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт орших Цагаансуварга дэд станцын 22 кВ-ын Мандах чиглэлийн шугамаас салбарлан 22/6 кВ-ын 2*5 МВА чадалтай дэд станцыг холбох горимын тооцоо, гүйцэтгэх ажлын задаргаа

2022.01.03

№	Үндсэн агуулга	Гүйцэтгэх ажил, тооцоо, судалгаа	Үнийн дүн, төгрөг
1	Өгөгдөл бүрдүүлэх	1. Тооцооны схем, өгөгдөл бүрдүүлэх 2. Тоноглол сонгох 3. Сонгосон тоноглолын техникийн өгөгдлийг тооцооны өгөгдөлд хөрвүүлэх 4. Тооцооны схем болон хувилбар сонгох	- - - -
2	Суурь тооцоотой холбоотой үндсэн судалгаа	5. Энергийн балансын судалгаа 6. Чадлын балансын судалгаа 7. Эх үүсвэрийн судалгаа, техникийн минимум, максимумын судалгаа	-
3	Программд оруулж, нягтлах	8. Шинэ тоноглолын мэдээллийг оруулах, тооцооны программд хөрвүүлж өгөгдөл оруулж, нягтлах 9. Өгөгдөлд нягтлаж, программын ажиллах боломжийг шалгах	1,125,000
4	Урьдчилсан тооцоо Хэрэглэгчийн холбох үеийг тогтсон горимын тооцоо	10. Чадлын урсгалын тооцоо, хүчдлийн горим нягтлах 11. Зуны бага ачааллын үеийн хамгийн бага ачааллын цагийн утгуудад тооцоог хийх 12. Зуны бага ачааллын үеийн хамгийн их ачааллын цагийн утгуудад тооцоог хийх 13. Өвлийн их ачааллын үеийн оргил ачааллын цагийн утгуудад тооцоог хийх 14. Өвлийн их ачааллын үеийн бага ачааллын цагийн утгуудад тооцоог хийх 15. Горим ажиллагааны хувилбаруудыг авч үзэх, тооцох, 16. Чадал болон хүчдлийн алдагдлыг тооцоолох	- - - 4,500,000 - - -
5	Урьдчилсан тооцооны дүгнэлт гаргах	17. Нэгдсэн сүлжээний горим ажиллагаанд урьдчилсан дүгнэлт гаргах шийдэл боловсруулах 18. Зөвлөмж боловсруулах	-
6	Горим ажиллагааг тодорхойлсон тооцооны дүгнэлт гаргах	19. Горим ажиллагаанд дүгнэлт гаргах 20. Шийдэл боловсруулах 21. Зөвлөмж боловсруулах 22. Дүгнэлт гаргах 23. Тайлан хүргүүлэх	3,375,000
	Үнэлгээ		9,000,000
	НӨАТ		900,000
	Нийт үнэлгээ		9,900,000

Хянасан: Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер  Б. Баатар
 Горим тооцоо, төлөвлөлтийн албаны дарга  Х. Болд-Эрдэнэ
 Горим тооцооны хэсгийн ахлах инженер  Ц. Сэргэлэн
 Гүйцэтгэсэн: Горим тооцооны инженер  Н.Буян-Өлзий